

# УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** УВА-2023/184/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Улаангом хот  
2023 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,

Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь

Утас: 70453317, Цахим хаяг:  
BatsuuriM@audit.gov.mn

Аудитын менежер: М.Бат-Амгалан

Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Авирмэд

Утас: 70453799, Цахим хаяг: AvirmedB@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



## АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	5
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	10
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....	11
4. Аудитын тайлан.....	14
4.1 Ерөнхий зүйл.....	14
4.2 Материаллаг байдал.....	14
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
5. Аудитын илрүүлэлт .....	16
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....	17

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**УВС АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,  
Ө.Бадрахын гудамж  
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,  
E-mail: uvs@audit.gov.mn

2023. 02. 06 № УВА-2023/184/НА-СТА-ТЦЗ  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН  
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН  
ДАРГА Д.ЦОГТ-ОЧИР  
ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд “Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр” анх удаа хэрэгжсэн байна.

### Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

### Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН (I)	1,768,248,903.00	3,039,639,903.00
33	АВЛАГА	1,768,248,903.00	3,039,639,903.00
33700	Хөтөлбөртэй холбоотой авлага	1,749,323,903.00	3,003,490,903.00
33703	Хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих	738,743,900.00	1,357,788,900.00
33705	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	178,077,003.00	237,997,003.00
33706	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	584,833,000.00	924,295,000.00
33717	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ	84,565,000.00	322,855,000.00
33718	Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих	163,105,000.00	150,555,000.00
33730	Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	-	10,000,000.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	18,925,000.00	35,825,000.00
33500	Бусад авлага	-	324,000.00
33520	Хувь хүмүүсээс авах авлага	-	324,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН (II)	-	-
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (III=I+II)	1,768,248,903.00	3,039,639,903.00
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР (IV)	-	162,000.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	162,000.00
41700	Хөтөлбөртэй холбоотой өглөг	-	162,000.00
41729	Ногоон ажлын байр хөтөлбөртэй холбоотой өглөг	-	162,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (V)	1,768,248,903.00	3,039,477,903.00
51	Засгийн газрын хувь оролцоо	1,768,248,903.00	3,039,477,903.00
51200	Хуримтлагдсан үр дүн	1,768,248,903.00	3,039,477,903.00
51210	Өмнөх үеийн үр дүн	1,768,248,903.00	1,768,248,903.00
51220	Тайлант үеийн үр дүн	-	1,271,229,000.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (VI=IV+V)	1,768,248,903.00	3,039,639,903.00

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	Өмнөх жилийн дүн	Тайлант жилийн дүн
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	773,073,200.00	2,459,013,000.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	16,800,000.00
1200	Өмчийн орлого	-	16,800,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	16,800,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	-	16,800,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	773,073,200.00	2,442,051,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	773,073,200.00	2,442,051,000.00



131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	30,007,800.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х	743,065,400.00	2,442,051,000.00
14	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО	-	162,000.00
140	Төсөвт байгууллагын орлого	-	162,000.00
140020	Дансны орлого	-	162,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	951,002,007.00	1,187,784,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	951,002,007.00	1,187,784,000.00
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	34,555,950.00	3,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,048,150.00	3,000,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,548,150.00	3,000,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,500,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	27,507,800.00	-
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	27,507,800.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	916,446,057.00	1,184,784,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	220,112,100.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	18,925,000.00
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	201,187,100.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,500,000.00	2,520,000.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,500,000.00	2,520,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	617,820,947.00	327,288,000.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	617,820,947.00	327,288,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	297,125,110.00	634,863,900.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	297,125,110.00	634,863,900.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	(177,928,807.00)	1,271,229,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV)	-	-
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	-	-
6	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI=III+IV-V)	(177,928,807.00)	1,271,229,000.00

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	Өмнөх жилийн дүн	Тайлант жилийн дүн
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	773,073,200.00	2,477,938,000.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	16,800,000.00
1200	Өмчийн орлого	-	16,800,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	16,800,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	-	16,800,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	773,073,200.00	2,460,976,000.00
1310	Улсын төсвөөс	-	18,925,000.00
131009	Оны эхний үлдэгдлээс санхүүжих	-	18,925,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	773,073,200.00	2,442,051,000.00

131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	30,007,800.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х	743,065,400.00	2,442,051,000.00
14	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО	-	162,000.00
140	Төсөвт байгууллагын орлого	-	162,000.00
140020	Дансны орлого	-	162,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	1,322,843,697.00	2,826,771,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,322,843,697.00	2,826,771,000.00
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	34,555,950.00	4,500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,048,150.00	4,500,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,548,150.00	4,500,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,500,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	27,507,800.00	-
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	27,507,800.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,288,287,747.00	2,822,271,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	18,925,000.00	220,112,100.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	18,925,000.00	18,925,000.00
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	201,187,100.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	16,800,000.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	16,800,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	580,183,947.00	348,833,000.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	580,183,947.00	348,833,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	689,178,800.00	2,236,525,900.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	689,178,800.00	2,236,525,900.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III=I-II)	(549,770,497.00)	(348,833,000.00)
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	-	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI=IV-V)	-	-
9	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	549,770,497.00	348,833,000.00
145	Бусад орлого (олз)	549,770,497.00	348,833,000.00
145004	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлээс эргэж төлөгдөх	549,770,497.00	348,833,000.00
10	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	-	-
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VII)	549,770,497.00	348,833,000.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII=III+VI+VII)	-	-

14	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
15	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын хөрөнгө оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	НИЙТ ДҮН
1	2021 оны 1-р сарын 1-ний үлдэгдэл	-	-	-	-
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгдөөгүй олз, гарз	-	-	-	-
7	Тайлант үеийн үр дүн	-	-	-	-
8	2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	-	-	1,768,248,903.0	1,768,248,903.0
8	2022 оны 1-р сарын 1-ний үлдэгдэл	-	-	1,768,248,903.0	1,768,248,903.0
9	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
10	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	1,768,248,903.0	1,768,248,903.0
12	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
11	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
13	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгдөөгүй олз, гарз	-	-	-	-
14	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
15	Тайлант үеийн үр дүн	-	-	1,271,229,000.0	1,271,229,000.0
16	2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	-	-	3,039,477,903.0	3,039,477,903.0

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Хөтөлбөр, зориулалт, эдийн засгийн ангилал		ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	
Код	Үзүүлэлт	Өмнөх жилийн дүн	Тайлант жилийн дүн
11000	Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл	-	-
00000	Төрийн сан	549,770,497.00	384,558,000.00
00000	Төрийн сан	549,770,497.00	384,558,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	549,770,497.00	384,558,000.00
26	Төвлөрүүлэх шилжүүлэг	549,770,497.00	384,558,000.00
261090	Төвлөрүүлэх шилжүүлэг	549,770,497.00	384,558,000.00
3	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>549,770,497.00</b>	<b>384,558,000.00</b>
32	<b>ЗГ-ын гадаадын төслийн зээл</b>	<b>549,770,497.00</b>	<b>348,833,000.00</b>
321102	Үндсэн төлбөр (ЗГ-ын дотоод зээл)	549,770,497.00	348,833,000.00
1400042	<b>Туслах үйл ажиллагааны орлого</b>	-	<b>16,800,000.00</b>
	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөр	-	16,800,000.00
33300	<b>Татаас санхүүжилтийн авлага</b>	-	<b>18,925,000.00</b>
	Санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтийн орлого	-	18,925,000.00
12000	Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
11000	Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл	-
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,442,213,800.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж	4,500,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	4,500,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,236,525,900.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,236,525,900.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	2,236,525,900.00
26	Төвлөрүүлэх шилжүүлэг	201,187,900.00
261090	Төвлөрүүлэх шилжүүлэг	201,187,900.00
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,442,213,000.00
30	Нэр данс, зөрүү, төсөл хөтөлбөрийн орлого	162,000.00
300015	Нэр данс, зөрүү, төсөл хөтөлбөрийн орлого	162,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,442,051,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,442,051,000.00
12000	Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан нь Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, иргэдэд нийгмийн халамжийн үйлчилгээг чанартай, үр дүнтэй, шуурхай хүргэх замаар нийгмийн тогтвортой хөгжлийг хангахад чиглэгдсэн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний төрийн бодлогыг харьяалах нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх гэсэн зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Хөдөлмөрийн тухай хууль - Шинэчлэн найруулгыг 2022 оны 01 сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн.
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль -2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр батлагдсан.
- ✓ Төрийн албаны тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 05-ны өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр нэмэлт өөрчлөлтүүд оруулсан байна.
- ✓ Төсвийн тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ний өдөр, 7 дугаар сарын 01-ний өдөр, 8 дугаар сарын 29-ний өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчаас эрсдэлд суурилсан дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,271,391.0 мянган төгрөгөөр буюу 71.9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/ Өөрчлөлт
	Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө		0.0	0.0	0.0
Авлага		1,768,248.90	3,039,639.9	1,271,391.0
Урьдчилгаа		0.0	0.0	0.0
Бараа материал		0.0	0.0	0.0
Үндсэн хөрөнгө		0.0	0.0	0.0
<b>Нийт хөрөнгө</b>		<b>1,768,248.9</b>	<b>3,039,639.9</b>	<b>1,271,391.0</b>
Өр төлбөр		0.0	162.0	162.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/		1,768,248.9	3,039,477.9	1,271,229.0
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>		<b>1,768,248.9</b>	<b>3,039,639.9</b>	<b>1,271,391.0</b>

Авлагын үлдэгдэл 3,039,639.9 мянган төгрөг болж 1,271,391.0 мянган төгрөгөөр өссөн нь 249 иргэнд 1,603,000.0 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгосноос шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3,039,477.9 мянган төгрөг болж 1,271,229.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь нь авлага нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн залруулга хийгдээгүй байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,285,874.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 2,285,874.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 156,177.0 мянган төгрөгөөр өсөж 2,442,051.0 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь шинээр хөтөлбөр нэмэгдэж батлагдаж ирсэнтэй холбоотой байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Эргэн төлөлтийн орлого 348,833.0 мянга, хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөр 16,800.0 мянга, урд оны татаас санхүүжилтийн авлага 18,925.0 мянга, нийт 384,558.0 мянган төгрөгийн орлогыг хүлээн зөвшөөрч, 348,733.0 мянган төгрөгийг төв сан руу төвлөрүүлж, 35,825.0 мянган төгрөгийг сангийн яам руу татсаныг татаас санхүүжилтийн авлагаар бүртгэсэн.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/						
д/д	Ангилал	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	72102/82612/213205	Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээ	17,600.0	17,600.0	0.0	100.0
2	72102/82613/213205	Ажилд зуучлах үйлчилгээ	8,400.0	8,400.0	0.0	100.0
3	72102/82618/213205	Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр	49,890.0	36,140.0	13,750.0	72.4
4	72102/82604/213205	Аж ахуй эрхлэгчдийг дэмжих хөтөлбөр	1,404,234.0	1,303,835.0	100,399.0	92.9
5	72102/82606/213205	Залуучуудын хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр	51,946.0	33,100.0	18,846.0	63.7
6	72102/82602/213205	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	185,225.0	165,193.0	20,032.0	89.2
7	72102/82609/213205	Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	278,200.0	276,912.0	1,288.0	99.5
8	72102/82612/213205	Ногоон ажлын байр хөтөлбөр, эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны зардал	442,056.0	395,021.9	47,034.1	89.4
9	72102/80224/210801	Аймгийн хөдөлмөр эрхлэлтийг салбар зөвлөлийн зардал	4,500.0	4,500.0	0.0	100.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 2,442,051.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 2,442,051.0 мянга төгрөгийн санхүүжилт хүлээн авч 2,240,863.9 төгрөгийн зарлага гарч тухайн оны санхүүжилтийн үлдэгдэл 201,187.1 төгрөг төвлөрүүлжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,240,863.9 мянган төгрөг буюу 91.7 хувьтай байгаа нь зардлыг 201,025.1 мянган төгрөгөөр хэмнэж, оны эцэст 162.0 мянган төгрөг нэр данс зөрүүгээр буцаж ирсэнтэй холбоотой байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

#### **3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**

Тайлант хугацаанд 7 хөтөлбөр 2 үйлчилгээг хэрэгжүүлсэн байна. Хэрэгжилтийн хувийг хүснэгт 2-т дэлгэрэнгүй харуулав.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Авирмэд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 38 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцож 7.6 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Гүйцэтгэлийн үе шатанд 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,187.8 сая төгрөгийн 1.0 хувь буюу 11.8 сая төгрөгөөс 80 хувиар тооцож 9.5 сая төгрөгөөр тогтоолоо.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн тухайн хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласан байна.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх,



нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан нь тайлант хугацаанд [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 137, хугацаа хоцроосон 12, хугацаа болоогүй хүлээгдэж байгаа 2 мэдээлэл байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан нь нийт 12 мэдээлэл, 1,599,449.5 мянган төгрөгийн 33 гүйлгээг шилэн дансны цахим хуудаст хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилд зөвлөмж өглөө.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2022 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	1	1,500.0	1	1,500.0	100
Зөвлөмж					
Нийт дүн					

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,599,449.5 мянган төгрөгийн 1 алдаа зөрчил илэрсэнд зөвлөмж өглөө.

#### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:



# 1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

## 1.1. Илрүүлэлт:

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан нь нийт 12 мэдээлэл, 1,599,449.5 мянган төгрөгийн 33 гүйлгээг шилэн дансны цахим хуудаст хугацаа хоцроож мэдээлсэн байна.

## 1.2. Өгсөн зөвлөмж:

Цаашид Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журмыг хэрэгжүүлэн ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
шилэн дансны цахим хуудаст хугацаа хоцроож мэдээлсэн.	1	1,599,449.5					1	1,599,449.5
Дүн	1	1,599,449.5					1	1,599,449.5
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР /М.БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР

/М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР

/Б.АВИРМЭД/

2023 оны 02 сарын 06-ны өдөр

